

**Бага насны хүүхдийн хөгжмийн чадамжийг хөгжүүлэх нь:  
Үйл ажиллагааны зохион байгуулалт**

Бага насны хүүхдийн хөгжмийн үйл ажиллагааг дараах чиглэлээр зохион байгуулна. Үүнд: Хөгжмийн хөгжүүлэх үйл ажиллагаа, хөгжмийн хамтын (хөгжмийн багш, бүлгийн багш, арга зүйч нар) үйл ажиллагаа, цэцэрлэгийн өдөр тутмын бүтээлч үйл ажиллагаа, хүүхдийн бие даасан хөгжмийн үйл ажиллагаа.

**Бага насны хүүхдийн хөгжмийн чадамжийг хөгжүүлэх арга, хэлбэр**

Бага насны хүүхдийн хөгжмийн үйл ажиллагааны арга хэлбэрүүд янз бүр байж болно. Жишээлбэл: Ганцаарчилсан, хэсэг бүлгээр, анги нийтээр, холимог байдлаар гэж зохион байгуулж болно. Өөрөөр хэлбэл хүүхдийн тоо үндсэн үзүүлэлт болж өгдөг байна.

Ганцаарчилсан хөгжмийн хичээлүүд нь хүүхэд бүрд тэдний бүтээлч чадварыг хөгжүүлэх, авьяасыг илрүүлэхээр зохион байгуулагддаг бол хэсэг бүлгийг долоо хоногт 2-3 удаа, 10-20 минутаар явагдахаар төлөвлөж болно. Анги нийтээрээ (фронтальные) гэдэг нь нэг насны нийт бүлгүүдэд нэгэн зэрэг явуулах боломжтой бол, холимог нь ялгаатай насны бүлгийн хүүхдүүдийг хамтад нь зохион байгуулахыг хэлнэ.

Хөгжмөөр хөгжүүлэх үйл ажиллагааг бүтцээр нь давамгайлсан, төрөлжсөн, нэгдмэл, сэдэвчилсэн, интеграцчилсан гэж ангилна.

1. Хөгжмийн үйл ажиллагаа нь бага насны хүүхдийн хөгжмийн авьяасыг хөгжүүлэх, тухайлбал (хэмнэлийн мэдрэмж, сонсголын мэдрэхүй, аяар чанга дуугаралт гэх мэт) хөгжүүлэх чиглэл бүхий практик үйл ажиллагаа;
2. Хүүхдийн (ойлгох, илэрхийлэх, бүтээх) бүхий л үйлийг ээлж дараатайгаар зохион байгуулах төрөлжсөн үйл ажиллагаа;
3. Урлагийн төрлүүд болох уран зураг, уран зохиол, хөгжим, театр, уран барилга зэргийг нэгдмэл байдлаар ойлгуулах хөгжүүлэх үйл ажиллагаа;
4. Зөвхөн нэг сэдвийн хүрээнд хөгжмийн сэдэвт хөгжүүлэх үйл ажиллагаа;
5. Сургалтын үйл ажиллагааны хөтөлбөрт урлагийн олон төрлийг тусган оруулснаар интеграцчилсан онцлог, сонирхолтой үйл ажиллагаа болно.

**Хөгжмийн үйл ажиллагааг зохион байгуулах хэлбэр**

Нас	Үйл ажиллагаа	Орчин үеийн хөгжмийн үйл ажиллагааны хэлбэрүүд
1-3 нас	Үйл гүйцэтгэж буй үйл явц	<ul style="list-style-type: none"><li>• Байгалийн болон ахуйн жижиг зүйлсийн дуу, хөгжмийн чимээ гаргах, тоглох турших</li><li>• Хөгжмийн өндөрлөгтэй болон өндөрлөггүй дуу чимээ гарган тоглох, давтах</li><li>• Сургалтын хэрэглэгдэхүүний цуглуулга хийх (шагшуур, энгийн хөгжмийн зэмсэг, хөгжимт тоглоомууд гэх мэт)</li><li>• Хөгжмийн дуугаралт, хэмнэлийг дуурайх, давтах</li><li>• Хөгжмийн болон хөгжмийн уран зохиолын оньсого</li><li>• Хөгжмийн гар хурууны болон логоритмт тоглоомууд</li><li>• Хөгжимт хөдөлгөөнүүд</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Хөгжимт үлгэрүүд (сонсох, гүйцэтгэх)</li> </ul>
3-5 нас	Тоглоом (хөгжимт, хөдөлгөөнт, сургах, жүжигчилсэн)	<ul style="list-style-type: none"> <li>Тодорхой сэдэвт хөгжимт жүжигчилсэн тоглоомууд (дуу-тоглоом)</li> <li>Зохиомжит хөгжимт тоглоомууд</li> <li>Хүндрүүлэх боломжтой туршилт, танин мэдэхүйн тоглоомууд ба хөгжимт аялал</li> <li>Хөгжмийн дидактик тоглоомууд</li> <li>Хөгжмийн зохиол бүхий этюд-тоглоом</li> <li>Жүжигчилсэн, сургах тоглоомууд</li> <li>Концерт-оньсогууд</li> <li>Хөгжмийн талаар хүүхдийн сонирхсон харилцан яриа</li> </ul>
5-6 нас	Интеграцчилсан хөгжүүлэх үйл ажиллагаа, сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Асуудал шийдвэрлэх нөхцөлт зорилтууд, олон хувилбарууд</li> <li>Хөгжмийн-дидактик тоглоомууд</li> <li>Компьютерийн хөгжимт тоглоомууд</li> <li>Судалгаат ажлууд</li> <li>Төсөлт ажлууд</li> <li>Жүжигчилсэн тоглолт</li> <li>Тойрон бүжиг</li> <li>Уралдаан, тэмцээн, фестиваль, концерт, хөгжмийн аялал, зугаалга, хөгжмийн музей</li> <li>Интеграцчилсан үйл ажиллагаа (урлагийн тоглолт)</li> <li>Хөгжмийн сонирхлын клуб</li> <li>Цуглуулга (жишээ нь хөгжмөөс төрсөн сэтгэгдлүүд гэх мэт)</li> </ul>

### Хөгжмийн үйл ажиллагааны арга аргачлал

Хөгжмийн үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны зорилго	Хөгжмийн үйл ажиллагааны арга, аргачлал, хэлбэрүүд
Сонсох	<ol style="list-style-type: none"> <li>Хөгжмийн зэмсгийн дуугаралтыг ялгах чадварыг хөгжүүлэх</li> <li>Аялгууг сонсоод хөгжмийн шинж төрх, хөгжмийн эгшиглэлтийг ялгах, хүрээлэн буй орчны дүрслэл, үйл явдал, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх</li> <li>Хөгжмийн төрөл зүйлийг тодорхойлох, хөгжмийн зохиолчийг таних</li> <li>Уран бүтээлийн талаар мэдрэмжээ илэрхийлэх, ярилцах, тайлбарлах</li> </ol>	<p>Хөгжмийн талаар харилцан яриа, хэлэлцүүлэг</p> <p>Хөгжмийн талаар асуултын наадам “Аяыг таа” хөгжмийн нэвтрүүлэг “Хөгжим юутай адилхан бэ?”, “Хөгжим юутай адилхан бэ?”, “Хөгжим сонсонгоо зуръя”, “Хөгжим сонсонгоо наадъя”, “Хөгжим сонсонгоо уншъя”, “Хөгжим сонсоод мэдэрье”.</p> <p>Хөгжмийн зүйрлэл</p> <p>Уран сэтгэмжит тоглоомууд</p> <p>Хөгжимт өнгөний загварчлал</p> <p>Хөгжимтэй зурах</p>

	5. Хөгжмийг сонсоод утга санаа, өнгө аясыг үгээр илэрхийлэх	
Гүйцэтгэх (Дуулах, хөгжмийн хэмнэлд тохирсон үйл ажиллагаа, энгийн хөгжмийн зэмсгээр тоглох)	Дуулах: 1. Дууны бүтээлийг хүлээж авах чадварыг хөгжүүлэх 2. Дууны нөөцтэй болгох 3. Дуулах чадварыг хөгжүүлэх 4. Дуулах дууны урын санг нэмэгдүүлэх	“Миний дуртай дуу”, “Бидний дуунууд” төсөлт ажил “Дуу хоолой”, “Хөгжмийн амжилтын цаг”, “Найрал ба харилцаа дууны наадам”, “Хүүхэлдэйн кино, үлгэр, зохиолын дуу зохион дуулцгаая” гэх мэт уралдаан Цээжээр зохиох ба холбоо үг, аман наадам Дуулалт-аман наадам

**Орчуулсан**                      **Б.Мөнхзаяа**  
Нийслэлийн боловсролын газар